



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/215/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-14
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18-19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ОРХОН СУМЫН НЭГДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
З.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА**

2025-02-25 № СЭА-2025/215/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус цэцэрлэг нь Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, стем тоглоомын тавиур, иргэдээс 270.0 төгрөгийн сүү, ногоо үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	108,034,307.78	162,962,989.12
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	56,486,317.30	81,593,328.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	56,486,317.30	81,593,328.70
3121	Төгрөг	56,486,317.30	81,593,328.70
31211	Төрийн сангийн харилцах	56,486,317.30	81,593,328.70
35	БАРАА МАТЕРИАЛ	51,547,990.48	81,369,660.42
351	Түүхий эд материал	145,455.00	200,455.00
3513	Эм боох материал	145,455.00	200,455.00
354	Хангамжийн материал	51,402,535.48	81,169,205.42
3541	Бичиг хэргийн материал	4,531,000.00	4,874,500.00
3542	Аж ахуйн материал	44,348,095.48	73,448,095.42
3545	Барилгын засварын материал	313,500.00	313,500.00
3546	Хүнсний материал	1,095,390.00	1,418,560.00
3547	Бусад хангамжийн материал	1,114,550.00	1,114,550.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	237,718,729.95	235,925,507.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	237,718,729.95	235,925,507.90
392	Биет хөрөнгө	227,765,938.38	226,134,174.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	241,220,700.00	241,220,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(43,107,771.00)	(51,729,325.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,674,989.43	54,419,989.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,383,975.36)	(28,620,681.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,236,821.00	11,236,821.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,139,424.85)	(9,154,632.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,360,195.00	17,360,195.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,095,595.84)	(8,598,891.48)
393	Биет бус хөрөнгө	9,952,791.57	9,791,333.44
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,255,208.43)	(1,416,666.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,708,000.00	9,708,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	345,753,037.73	398,888,497.02
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	345,753,037.73	398,888,497.02
51	Засгийн газрын хувь оролцоо	345,753,037.73	398,888,497.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	80,539,140.00	80,539,140.00
51101	Өмч: - төрийн	80,539,140.00	80,539,140.00
512	Хуримтлагдсан үр дүн	64,556,222.18	117,691,681.47
5121	Өмнөх үеийн үр дүн	64,556,222.18	64,556,222.18
5122	Тайлант үеийн үр дүн		53,135,459.29
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,657,675.55	200,657,675.55
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	345,753,037.73	398,888,497.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	425,635,147.78	630,772,214.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		27,614,999.94
120	Нийтлэг татварын бус орлого		27,614,999.94
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		9,745,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		17,869,999.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	425,635,147.78	603,157,214.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382,407,600.00	550,445,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,407,600.00	550,445,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,227,547.78	43,211,414.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,227,547.78	43,211,414.65
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	405,658,586.21	577,636,755.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	405,658,586.21	577,636,755.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,658,586.21	577,636,755.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,996,998.21	412,533,520.97
210101	Үндсэн цалин	208,575,651.02	281,561,800.25
210102	Нэмэгдэл	50,298,103.49	116,327,255.36
210104	Урамшуулал	9,123,243.70	14,644,465.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,457,048.54	51,088,367.63
210201	Тэтгэврийн даатгал	24,160,023.25	35,132,452.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,517,170.38	4,312,380.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,947,736.34	2,115,990.68
210204	Ажилгүйдлийн даатгал	472,417.45	1,890,748.27
210205	Эрүүл мэндийн даатгал	5,359,701.12	7,636,795.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,114,947.78	38,211,414.65
210301	Гэрэл, цахилгаан	5,068,527.75	5,134,993.77
210302	Түлш, халаалт	33,076,420.03	33,076,420.88
2105	Нормативт зардал	29,836,140.00	36,101,230.00
210502	Хоол, хүнс	29,836,140.00	36,101,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,382,600.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,382,600.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	595,000.00	1,272,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	595,000.00	1,272,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,245,851.68	33,429,722.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,203,051.40	11,949,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,261,300.00	3,942,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,781,500.28	17,538,222.05
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	19,976,561.57	53,135,459.29
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	19,976,561.57	53,135,459.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	425,635,147.78	603,157,214.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	425,635,147.78	603,157,214.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382,407,600.00	550,445,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,407,600.00	550,445,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,227,547.78	43,211,414.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,227,547.78	43,211,414.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	384,663,345.93	578,050,203.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,663,345.93	578,050,203.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,663,345.93	578,050,203.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,438,227.64	412,533,520.97
210101	Үндсэн цалин	204,213,425.37	281,561,800.25
210102	Нэмэгдэл	53,101,558.57	116,327,255.36
210104	Урамшуулал	9,123,243.70	14,644,465.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,015,819.11	51,088,367.63
210201	Тэтгэврийн даатгал	24,770,744.54	35,132,452.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,904,953.09	4,312,380.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,248,722.50	2,115,990.68
210204	Ажилгүйдлийн даатгал	548,229.96	1,890,748.27
210205	Эрүүл мэндийн даатгал	5,543,169.02	7,636,795.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,144,947.78	38,211,414.65
210301	Гэрэл, цахилгаан	5,068,527.75	5,134,993.77
210302	Түлш, халаалт	33,076,420.03	33,076,420.88
2105	Нормативт зардал	30,363,400.00	36,154,400.00
210502	Хоол, хүнс	30,363,400.00	36,154,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,382,600.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,382,600.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	595,000.00	1,272,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	595,000.00	1,272,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,723,351.40	33,790,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,934,351.40	29,707,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,789,000.00	4,082,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	37,871,801.85	25,107,011.40
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	37,871,801.85	25,107,011.40
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,614,515.45	56,486,317.30
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,486,317.30	81,593,328.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,539,140.00	200,657,675.55	64,556,222.18	345,753,037.73
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			53,135,459.29	53,135,459.29
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,539,140.00	200,657,675.55	117,691,681.47	398,888,497.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	665,239,600.00	578,050,203.25	87,189,396.75	86.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	665,239,600.00	578,050,203.25	87,189,396.75	86.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,239,600.00	578,050,203.25	87,189,396.75	86.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,046,800.00	412,533,520.97	64,513,279.03	86.5
210101	Үндсэн цалин	320,897,100.00	281,561,800.25	39,335,299.75	87.7
210102	Нэмэгдэл	147,459,800.00	116,327,255.36	31,132,544.64	78.9
210104	Урамшуулал	8,689,900.00	14,644,465.36	(5,954,565.36)	168.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,793,700.00	51,088,367.63	5,705,332.37	90.0
210201	Тэтгэврийн даатгал	38,620,300.00	35,132,452.91	3,487,847.09	91.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,542,800.00	4,312,380.16	230,419.84	94.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,271,800.00	2,115,990.68	155,809.32	93.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,271,800.00	1,890,748.27	381,051.73	83.2
210205	Эрүүл мэндийн даатгал	9,087,000.00	7,636,795.61	1,450,204.39	84.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,861,400.00	38,211,414.65	5,649,985.35	87.1
210301	Гэрэл, цахилгаан	7,800,000.00	5,134,993.77	2,665,006.23	65.8
210302	Тулш, халаалт	36,061,400.00	33,076,420.88	2,984,979.12	91.7
2105	Нормативт зардал	45,861,200.00	36,154,400.00	9,706,800.00	78.8
210502	Хоол, хүнс	45,861,200.00	36,154,400.00	9,706,800.00	78.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00		100.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,272,500.00	1,272,500.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,272,500.00	1,272,500.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,404,000.00	33,790,000.00	1,614,000.00	95.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,321,500.00	29,707,500.00	1,614,000.00	94.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,082,500.00	4,082,500.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	665,239,600.00	603,157,214.65		100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	559,995,800.00	559,945,800.00		100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	550,445,800.00	550,445,800.00		100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,550,000.00	9,500,000.00		100.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,550,000.00	9,500,000.00		100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,861,400.00	43,211,414.65	5,649,985.35	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	48,861,400.00	43,211,414.65	5,649,985.35	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	56,382,400.00		56,382,400.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	56,382,400.00			
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		56,486,317.30	(56,486,317.30)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		81,593,328.70	(81,593,328.70)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхон сумын нэгдүгээр цэцэрлэг нь “Хүүхдийг бүх талаар тэгш хөгжүүлэн эрүүл биетэй, саруул ухаантай сайн хүн болгох үндсийг тавих” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн эрхийг дээдэлж, ээлтэй сургалтын орчинг бүрдүүлэх,
- СӨБ-ийг олон хэлбэр хувилбарт чиглэлээр чанартай олгож хүүхэд бүрийг бүх талаар хөгжүүлэх,
- Бага насны хүүхдийг ардын ёс заншилд суралцуулах,
- Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсролыг дээшлүүлэх СӨБ-д оролцох олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,135.5 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	56,486.3	81,593.3	25,107.0
Авлага	-	-	-
Бараа материал	51,548.0	81,369.7	29,821.7
Үндсэн хөрөнгө	237,718.7	235,925.5	(1,793.2)
Нийт хөрөнгө	345,753.0	398,888.5	53,135.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	345,753.0	398,888.5	53,135.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	345,753.0	398,888.5	53,135.5

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 81,593.3 мянган төгрөг болж 25,107.0 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 81,369.7 мянган төгрөг болж 29,821.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 65,455.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, стем тоглоомын тавиур, иргэдээс 270.0 төгрөгийн сүү, ногоо үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 53,504.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 235,925.5 мянган төгрөг болж 1,793.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,000.0 мянган төгрөгийн худгийн цэвэр усны нөөцийн сав, аймгийн Боловсролын газраас 9,745.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер үнэ төлбөргүйгээр хүлээн авч, хөрөнгөд 17,538.2 мянган төгрөгийн элэгдэл тооцоноос шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 274,022.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 48,861.4 мянган төгрөг нийт 322,883.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 342,356.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 616,378.2 мянган төгрөгөөр, нийт 665,239.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 550,445.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 48,861.4 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 56,382.4 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **665,239.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 300,566.2 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,272.5 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 15,454.7 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 25,062.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 665,239.6 мянган төгрөгийн орлого

бүрдүүлснээс, урсгал үйл ажиллагаанд 578,050.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 578,050.1 мянган төгрөг буюу 86.9 хувьтай байгаа нь хоолны зардлыг 9,706.8 мянган төгрөгөөр, боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 71,279.7 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	616,378.2	534,838.7	81,593.3	86.8
80233 - Хүүхэд хамгаалал	544.9	544.9	-	
81605 - Эрүүл мэндийг дэмжих	942.0	860.0	82.1	91.3
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	45,861.2	36,154.4	9,706.8	78.8
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,088.8	2,088.5	0.3	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	1,010.6	590.0	420.6	58.4
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	550,696.5	479,416.8	71,279.7	87.1
81833- Явуулын багшийн үйлчилгээ	1,562.4	1,562.4	103.7	100.0
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	4,121.8	4,121.7	0.1	100.0
83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	9,550.0	9,500.0	-	99.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,861.4	43,211.4	5,650.0	88.4
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	48,861.4	43,211.4	5,650.0	88.4
ДҮН	665,239.6	578,050.1	87,243.3	86.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэг хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	24,931.9	24,931.9	ХТШ
	Нийт дүн	24,931.9	24,931.9	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа дараах багцуудад хуваан харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зарласан.

Багц – 1 Мах, махан бүтээгдэхүүн

Багц – 2 Хүнсний ногоо,

Багц – 3 Гурил, гурилан бүтээгдэхүүн

Багц – 4 Сүү цагаан идээ

Бэлтгэн нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Прогресс агро” ХХК, иргэн Б.Наран-Уул, Д.Мандах, Түмэнбаяр, Алтанцэцэг нартай гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 405,658.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,084.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 167 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Үүнд: Хугацаа хоцроосон:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал – 1 удаа
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт – 1 удаа
- Санхүүгийн тайлан – 1 удаа

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан – 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/48 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,579.5 мянган төгрөгийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж албан шаардлага, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроосон 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 2 зөрчлийг арилгаж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх 1 зөрчлийг давтан гаргаж 66.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	2,579.5	1	2,579.5	100.0
Зөвлөмж	2	-	1	-	50.0
Нийт дүн	3	2,579.5	2	2,579.5	66.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 28,565.6 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Аймгийн Боловсролын газраас нийлүүлсэн 17,600.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, иргэдээс хандивласан 270.0 мянган төгрөгийн сүү, ногоо зэрэг нийт 17,870.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлогыг үр дүнгийн тайланд буруу тусгасан,
- Үр дүнгийн тайланд 925.5 мянган төгрөгийн зардлыг буруу ангилан бүртгэсэн,
- Үр дүнгийн тайланд 4,476.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тусгаагүй.
- Урсгал засварт зарцуулсан 5,293.7 мянган төгрөгийн бараа материалыг үлдэгдлээр тайлагнан санхүүгийн байдлын тайланг буруу илэрхийлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **10,973.0** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

1. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр шаардлага хангах түвшинд үнэлэгдээгүй багш Б.Баярмаад 1,069.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.4 "...багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн багшид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд заасан мөнгөн урамшууллыг доор дурдсан хувь хэмжээгээр албан тушаалын сарын үндсэн цалингаас тооцож олгоно. "I - IV түвшин" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн урамшуулал цалин хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:**

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 9,903.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.” 14.4.1: “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5: “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй орлогыг буруу тусгасан	1	17,870.0			1	17,870.0	1	17,870.0				
Зардлын дансны ангилал буруу бүртгэсэн	1	925.5			1	925.5	1	925.5				
Элэгдэл дутуу байгуулсан	1	4,476.5	1	4,476.5			1	4,476.5				
БМ-ын үлдэгдлийг буруу илэрхийлсэн.	1	5,293.7			1	5,293.7	1	5,293.7				
Дүн	4	28,565.6	1	4,476.5	4	24,089.1	4	28,565.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлэгдээгүй багшид үр дүнгийн урамшуулал бодож олгосон.	1	1,069.8	1	1,069.8								

Үнэ төлбөргүй орлогыг бүртгэлд тусгаагүй	1	9,903.2				1	9,903.2				
Дүн	2	10,973.0	1	1,069.8		1	9,903.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 4 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	-			1	-		